

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БУА-2020/01/СТА-ТЕЗ

БУЛГАН АЙМАГ 2019 ОН

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 7034-2580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodoli@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Утас: 9907-9641 Цахим хаяг: tserenlhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1. БАТЛАГДСАН ТӨСӨВТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХДАА ОНЫ ЭХНИЙ ҮЛДЭГДЛИЙГ 28.6 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЭН БАТАЛСАН БАЙНА.	8
1.1 Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны төсвийн орлогыг үндэслэл муутай, өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан өндөр төлөвлөсөн байна.....	8
1.2 Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогын төлөвлөгөө тасарснаас орон нутгийн орлогын төлөвлөгөө биелээгүй, газрын төлбөрийн ногдуулалтын тооцоо хийгээгүй байна.	10
БҮЛЭГ 2. ГАДААД АЛБАН ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ҮНЭН ЗӨВ ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.....	12
2.1 УИХ-аар төсвийн жилд зарцуулах зардлыг 1209.2 сая төгрөгөөр буюу 1.9 хувиар нэмэгдүүлэн баталсан байна.	12
2.2 Гадаад албан томилолтын зардал олгосон 39.2 сая төгрөгийг буруу төлөвлөн зарцуулсан байна.....	13
БҮЛЭГ 3. АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2019 ОНД ХҮРЭХ ҮР ДҮНГ ТОДОРХОЙЛОН БАТАЛСАН БОЛОВЧ ДОТООД АУДИТ ХИЙГЭЭГҮЙ БАЙНА.....	19
3.1 Аймгийн ТЕЗ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тоо болон чанарын үзүүлэлтийн хүрэх үр дүнг тодорхойлон баталсан боловч дүгнэж, нэгтгэж, дүн шинжилгээ хийж ажиллаагүй байна.	129
3.2 Төсвийн ТЕЗ нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтэд дотоод хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.	
БҮЛЭГ 4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 94.4 ХУВИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ БАЙНА.....	21
БҮЛЭГ 5. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ӨМНӨХ ОНООС 1903.9 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДСЭН БАЙНА	21
ДҮГНЭЛТ:.....	22
ЗӨВЛӨМЖ:.....	22

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
БСШУСС	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨК	Орон нутгийн өмчит компани
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТАМНАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ТҮА	Тохижилт үйлчилгээний анги
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
УИХ	Улсын Их Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГ	Засгийн газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ЭӨЦС	Эрдмийн өргөө цогцолбор сургууль
ЭМС	Эрүүл мэндийн сайд

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орон нутгийн төсвийн төлөвлөлтийн судалгаа	6
Хүснэгт 2	Татварын орлогын төлөвлөгөөний нэмэгдүүлсэн судалгаа	8
Хүснэгт 3	Орлогын төлөвлөгөөний биелэлт	10
Хүснэгт 4	Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт, эх үүсвэр	12
Хүснэгт 5	Аудитлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
Хүснэгт 6	Төсвийн зарлагын харьцуулалт	13
Хүснэгт 7	Төсвийн гүйцэтгэлийг төлөвлөгөө, гүйцэтгэлийг сумдаар	14

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Төсвийн эх үүсвэр	8
Дүрслэл 2	Тусгай зориулалтын шилжүүлэг	8
Дүрслэл 3	Орон нутгийн орлогын төлөвлөгөө	9
Дүрслэл 4	Зардлын төлөвлөлт	13

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2020 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Төрийн аудитын байгууллагын 2020 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>Булган аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2019 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдснийг шалгаж, дүгнэлт гарган ҮАГ, аймгийн ТЕЗ-д хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.</p> <p>Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ ТЕЗ-ийн 2019 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх ➢ ТЕЗ-ийн 2019 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж буй эсэх ➢ ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтод түвшинд нийцсэн эсэх
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4200, төрийн хяналт шалгалтын стандарт, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p> <p>Хууль эрх зүйн дараах актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд.</p> <ul style="list-style-type: none"> ➢ Монгол Улсын үндсэн хууль ➢ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль ➢ Төсвийн тухай хууль ➢ Төрийн аудитын тухай хууль ➢ Монгол улсын 2019 оны төсвийн тухай хууль ➢ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль ➢ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль ➢ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль ➢ Татварын багц хуулиуд ➢ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль ➢ Шилэн дансны тухай хууль ➢ Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд ➢ Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Д.Анхбаяр удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Г.Цэрэнлхам нар 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.</p>

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ИТХ-ын худалдааны 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолоор аймгийн 2019 оны төсвийн орлогыг 61026.9 сая төгрөгөөр баталсан боловч Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3¹-т зааснаар Сангийн яамнаас зарцуулах зөвшөөрөл олгосны дагуу урьд оны үлдэгдлийг 4224.1 сая төгрөгөөр буюу 1209.2 сая төгрөгийг нэмэгдүүлэн зарцуулахаар баталсан байна.

Үүнээс улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 35091.7 сая, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогоор 22872.6 сая, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор 3062.5 сая төгрөг оруулж, урьд оны үлдэгдлээс 4224.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг бүрэн авч, орон нутгийн орлогоос 21977.1 сая төгрөгийг оруулж, орон нутгийн орлогын төлөвлөгөө 287.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт 1. Орон нутгийн төсвийн төлөвлөлтийн судалгаа

№	Үзүүлэлт	УИХ-ын баталсан дүн	/мян.төг/ 2019 он	
			Анх батлагдсан	Үлдэгдэл хуваарилсан эцсийн төлөвлөгөө
А	Б	1	2	3
	ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар		2018.12.05 10/07	2019.09.27 13/01
	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО			
	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	21,716,715.0	61,026,891.9	61,026,891.9
	ХӨРӨНГИЙН ОРЛОГО	20,000.0	20,000.0	20,000.0
	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО		35,071,785.6	35,071,785.6
	БУСАД ЭХ ҮҮСВЭР		3,062,477.4	3,062,477.4
	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА			
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,007,098.5	64,041,779.0	65,250,998.9
	УРСГАЛ ЗАРДАЛ	23,007,098.5	59,633,012.1	60,599,481.6
	УРСГАЛ ТЭНЦЭЛ	(1,310,383.5)		
	НИЙТ ТЭНЦЭЛ	(1,290,383.5)	(3,014,887.1)	(4,224,107.0)
	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР			
	1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт			
	2. Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих		3,014,887.1	4,224,107.0

Аймгийн ТЕЗ-ийн гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагааны зардалд 58914.8 сая, хөрөнгийн зардалд 1753.7 сая төгрөгийг зарцуулж, төсөвт зардлыг 4582.5 сая төгрөгийг хэмнэсэн байна.

¹ Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3²-т зааснаар Сангийн яамнаас зарцуулах зөвшөөрөл олгосны дагуу урьд оны үлдэгдлийг 4224.1 сая төгрөгөөр буюу 1209.2 сая төгрөгийг нэмэгдүүлэн зарцуулахаар баталсан байна.

Аудит хийхэд учирсан хүндрэл бэрхшээл:


Булган аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийхэд аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн тус бүрээр гаргаж ирүүлээгүй, төсвийн орлого, зарлагын нэгдсэн судалгаа хангалтгүй, зөрүүтэй тоон мэдээллийг дахин тулган баталгаажуулахад цаг хугацаа их зарцууллаа.

² Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна.

БҮЛЭГ 1. БАТЛАГДСАН ТӨСӨВТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХДАА ОНЫ ЭХНИЙ ҮЛДЭГДЛИЙГ 28.6 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЭН БАТАЛСАН БАЙНА.

1.1. Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны төсвийн орлогыг үндэслэл муутай, өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан өндөр төлөвлөсөн байна.

Монгол улсын 2019 оны төсвийн тухай хуулиар батлагдсанаар Булган аймгийн Засаг дарга Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу санхүүгийн дэмжлэгээр 1310.3 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр 30191.3 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 3570.1 сая, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоос 3062.5 сая төгрөгийг хуваарилсан бөгөөд аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 22892.6 сая төгрөгөөр тооцож, урьд оны үлдэгдлээс 4224.1 сая төгрөгөөр санхүүжүүлж нийт 65250.9 сая төгрөгийг төвлөрүүлэн зарцуулахаар төсөв батлагдсан байна.



Тусгай зориулалтын шилжүүлгээр эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээнд 5049.5 сая, ерөнхий боловсролын үйлчилгээнд 17156.9 сая, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 7018.5 сая, газрын харилцаа кадастрын үйлчилгээнд 446.0 сая, Хүүхэд хөгжил хамгааллын үйлчилгээ 224.5 сая, Насан туршийн боловсрол 101.9 сая, Өрхийн эмнэлэг 194.0 сая төгрөгийг тус тус зарцуулахаар баталсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн татварын орлогыг 22892.6 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс аймгийн нэгдсэн төсөвт төвлөрүүлэх орлогыг 20106.7 сая, сумдын татварын орлогыг 2785.9 сая төгрөгөөр оруулахаар төлөвлөжээ.

Хүснэгт №2 Татварын орлогын төлөвлөгөөний нэмэгдүүлсэн урсгал орлого

Д/д	Орлогын төрөл	2018 оны гүйцэтгэл	УИХ-ын баталсан	2019 оны төлөвлөгөө /өөрчлөлт /	Өөрчлөлт	
					Өмнөх оны гүйцэтгэлээс	СЯ-ны хянаснаас
1	УРСГАЛ ОРЛОГО	25,516,315.3	21,716,715.0	22,892,628.9	2,623,686.4	1,176,000.0
1.1	Аймгийн төсвийн дүн	20,589,169.6	19,136,549.0	20,106,700.0	482,469.6	970,151.0
1.2	Орон нутгийн төсвийн дүн	4,952,658.2	2,580,166.0	2,785,928.9	(2,166,729.3)	205,762.9

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолууд

Аймаг, сумдын ИТХ-ын хуралдаанаар Булган аймгийн 2019 оны төсвийн орлого, эх үүсвэрийг баталсан дүнг тулган баталгаажуулснаар 65250.9 сая төгрөг байна. Үүнд:

- Аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын буюу татварын бус орлогыг, буцаан олголтыг хассанаар 3657.3 сая төгрөгөөр,
- Сум, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 2785.9 сая төгрөгөөр,
- Аймгийн төсвийн урьд оны үлдэгдлийг 2425.9 сая, сумдын төсвийн урьд оны үлдэгдлийг 1568.2 сая, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлийг 230.0 сая төгрөгөөр,
- Төсөвт байгууллагын өөрийн орлого, эх үүсвэрийг сум хөгжүүлэх сан 1888.5 сая, байгаль хамгаалах сан 327.9 сая, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан 147.9 сая, төсвийн байгууллагын өөрийн орлогыг 265.1 сая, туслах үйл ажиллагааны орлогыг 110.9 сая төгрөгөөр,
- Аймаг, сумдын ОНХС-д олгох шилжүүлгийг 3570.1 сая төгрөгөөр,
- Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгийг 29770.8 сая төгрөгөөр,
- Улсаас олгох санхүүгийн дэмжлэгийг 1310.3 сая төгрөгөөр,
- Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг 420.5 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн дүнгээр 2019 онд орон нутгийн орлогоор 22872.6 сая төгрөг төвлөрүүлэхээр тооцсон бөгөөд орлогын нэр төрөл дараах байдалтай байна.



Аймгийн татварын орлогыг төлөвлөхдөө Сангийн яамнаас хянасан орлогыг 1195.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь 2018 онд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого 16186.3 сая төгрөг орсонтой холбоотой байна.

Орлогын нэр төрлөөр нь авч үзвэл Сангийн яаманд ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж, байгалийн ургамал ашигласны төлбөр, бусад орлогыг хянуулаагүй, хадгаламжийн хүүгийн орлого, үл хөдлөх хөрөнгө борлуулсны татвар, ТТАМНАТ, хүү торгуулийн орлого, нэр заагдаагүй бусад орлогыг өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан нэмэгдүүлжээ.

Харин шууд бус орлого, бууны татвар, улсын тэмдэгтийн хураамж, ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн орлогыг УИХ-ын баталсан дүнгээс бууруулан баталсан байна.

2019 оны нийт орлого эх үүсвэрийн батлагдсан төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулбал 108.3 хувиар буюу 5032.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Татварын болон татварын бус орлого 1951.5 сая, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 1257.9 сая, төсвийн шилжих үлдэгдэл 689.5 сая төгрөгөөр өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

1.2. Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогын төлөвлөгөө тасарснаас орон нутгийн орлогын төлөвлөгөө биелээгүй, газрын төлбөрийн ногдуулалтын тооцоо хийгээгүй байна.

Орон нутгийн төсвийн орлого 22264.5 сая төгрөгийг төлөвлөснөөс 21977.1 сая төгрөг оруулж, 1105.7 сая төгрөгөөр тасалсан байна.

Хүснэгт № 3 Орлогын төлөвлөгөөний биелэлт

/мян.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	61,026,891.90	59,921,201.18	(1,105,690.72)	98.2
ТАТВАРЫН ОРЛОГО	22,264,501.90	21,977,071.26	(287,430.64)	98.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,762,390.00	37,944,129.93	(818,260.07)	97.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	35,071,785.60	34,707,570.10	(364,215.50)	99.0

Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн мэдээлэлд суурилав.

Орон нутгийн төсвийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл орлогын албан татвар 252.6 сая, үйл ажиллагааны орлого 55.2 сая, хөрөнгийн орлого 96.3 сая, хөрөнгийн албан татвар 84.9 сая, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 55.9 сая, АТБӨЯХАТатвар 43.9 сая, ТТАМНАТөлбөр 30.7 сая, хувьцааны ногдол ашиг 22.2 сая, хүүгийн орлого 262.3 сая, хөрөнгө борлуулсны орлого 30.4 сая төгрөгөөр тус тус биелсэн ч, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого 1153.2 сая төгрөгөөр тасарсан байна.

Аймгийн төсвийн орлогын давсан, тасарсан шалтгааныг нэр төрлөөр нь авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

1. Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг Сангийн яам 14579.8 сая төгрөгөөр хянасныг 686.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 15500.0 сая төгрөгөөр өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн өндөр төлөвлөсөн боловч “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ дотоод эргэлтийн далангийн ус буюу саарал усыг их ашигласан, 3-р сард ТӨҮГ болгож, МУ-ын Засгийн газраас онц байдал тогтоосонтой холбогдуулан хэмнэлтийн горимд шилжсэн, ЗГ-ын 2018 оны 391-р тогтоолоор зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усанд төлбөрийг шатлан өсгөх хувь хэмжээгээр оногдуулах болсонтой холбоотой усыг төлөвлөснөөс илүү хэмжээгээр ашиглахаас зайлсхийж төлөвлөсөн зэргээс шалтгаалан орлого тасарсан гэсэн тайлбарыг аймгийн Татварын хэлтэс ирүүлсэн.

2019 онд гүйцэтгэлээр үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого 14346.8 сая төгрөг төвлөрснөөс 2016-2018 оны уул уурхайн компанийн ашигласан усны төлбөрийн орлогын дутуугаас 899.6 сая, 2019 оны 977.1 сая, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 12470.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2. Газрын төлбөрийн орлогыг 245.0 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 756.5 сая төгрөгийг төвлөрүүлж, 511.5 сая төгрөгөөр буюу 208.8 хувиар давуулан биелүүлсэн байна. Засгийн газрын 2018 оны 182-р тогтоолоор газрын төлбөрийн суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээ өссөн, газрын дуудлага худалдаагаар 152.0 сая, өмнөх оны газрын төлбөрийн орлогын

дутуугаас 51.8 сая төгрөг төвлөрсөнтэй холбоотой уг орлого давж биелсэн байна. Хэдийгээр газрын төлбөрийн орлого давж биелсэн ч ногдуулалтыг нэг бүрчлэн тооцож, судалгаа шинжилгээ хийгээгүй байна.

Сумдын орон нутгийн төсвийн орлогын давсан, тасарсан шалтгааныг нэр төрлөөр нь авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 29 дүгээр тогтоолоор согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах тэмдэгтийн хураамжийн хэмжээг бууруулснаас шалтгаалан улсын тэмдэгтийн хураамж 31.8 сая төгрөгөөр буюу 17.1 хувиар,
2. Галт зэвсэг эзэмшигч хөдөлгөөн өөрчлөлтийг цагдаагийн газраар тухай бүр хийлгээгүй, татварын байцаагчийн ажлын гүйцэтгэлээс шалтгаалж бууны албан татвар 14.9 сая төгрөгөөр буюу 22.5 хувиар,
3. Сумдын Засаг дарга хамтран ажиллах гэрээг оны дундуур хугацаа алдаж Эрдэнэт Булган цахилгаан түгээх сүлжээ компанийн харьяа салбар газруудтай хог хаягдлын хураамжийг хураах гэрээг оны дундуур байгуулсантай холбоотойгоор хог хаягдлын хураамжийн орлого 2.2 хувиар,
4. Байгаль орчин аялал, жуулчлалын яамнаас халиун буга, агнуурын шувуу, тул загас барих / буцааж тавих/ агнах эрхийн зөвшөөрлийг бага хэмжээтэй олгосноос агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлого 19.8 сая төгрөгөөр буюу 54.4 хувиар тус тус тасарч,
5. Эрдэнэт үйлдвэр Орхон аймгаас Олимп амралт хүртэлх замыг аадар бороо их бороо их орсны улмаас 4 удаа зассан, Баатарван амралтын газар онгоцны буудал барьж, ашиглалтад оруулсан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Булган-Хишиг-Өндөр чиглэлийн 13 км хатуу хучилттай авто зам баригдаж нэг удаагийн шинжтэй орлогоос шалтгаалан ТТАМНАТ-ийн орлого давсан байна.

БҮЛЭГ 2. ГАДААД АЛБАН ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ҮНЭН ЗӨВ ТАЙЛАГНААГҮЙ БАЙНА.

2.1. УИХ-аар төсвийн жилд зарцуулахаар батлагдсан зардлыг 1209.2 сая төгрөгөөр буюу 1.9 хувиар нэмэгдүүлэн баталсан байна.

Булган аймгийн 2019 оны төсвийн төслийг боловсруулах, батлах харилцааг Монгол Улсын төсвийн тухай хуулиар зохицуулж байна. Аймгийн ТЕЗ-ийн 2019 онд зарцуулах зарлагын нийт хэмжээг аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор 65250.9 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Х хуралдааны 10/07 дугаар тогтоолоор аймгийн 2019 онд зарцуулах зарлагын төлөвлөгөөг 65250.9 сая төгрөгөөр,
- Тогтоолын нэгдүгээр хавсралтаар ТЕЗ нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийг, 2019 оны зорилтод түвшингийн хамт,
- Сумдын ИТХ-ын хуралдаанаас орон нутгийн төсвийн зарлагыг 12490.8 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих зардлыг 30191.3 сая, ТЗШ-ийн байгууллагын байр ашиглалттай холбоотой зардлыг 4509.4 сая, соёлын байгууллагын зарлагыг 1432.1 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Орон нутгийн төсвийн зарлагыг төсөл хөтөлбөр, арга хэмжээ тус бүрээр ангилан авч үзвэл:

Хүснэгт №4 Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт, эх үүсвэр / мян.төг /

№	Орлого зардлын төрөл	Анх батлагдсан дүн	Үлдэгдэл хуваарилсан төлөвлөгөө	Өөрчлөлт
1	Аймгийн ТЕЗ-ийн нийт орлогын эх үүсвэр	64,041,779.0	65,250,998.9	1,209,219.9
1.1	Аймгийн 2019 оны төсөвт төвлөрүүлэх орлого	22,892,628.9	22,892,628.9	-
1.2	Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	1,310,383.5	1,310,383.5	-
1.3	Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг	3,570,071.1	3,570,071.1	-
1.4	Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох ТЗШ	30,191,331.0	30,191,331.0	-
1.5	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,062,477.4	3,062,477.4	-
1.6	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,014,887.1	4,224,107.0	1,209,219.9
2	Аймгийн 2019 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээ	64,041,779.0	65,250,998.9	1,209,219.9
2.1	Аймгийн ИТХ	491,994.6	511,069.6	19,075.0
2.1.1	Аймгийн Засаг даргын харьяаны байгууллага	63,549,784.4	64,739,929.3	1,190,144.9
	Сумд	47,934,137.5	48,623,649.6	689,512.1
2.1.2	Булган аймаг	15,615,646.9	16,116,279.7	500,632.8

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолууд

Урсгал зардлыг өмнөх оноос 13174.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 65383.6 сая, хөрөнгийн зардлыг 3272.9 сая төгрөгөөр бууруулж 1856.2 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Хөрөнгийн зардлыг өмнөх оноос 297.2 сая төгрөгөөр 5.5 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн байна.



2.2 Гадаад албан томилолтын зардлыг 39.2 сая төгрөгийг буруу төлөвлөн зарцуулсан байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар:

ТЭЗ-ийн 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага батлагдсан төлөвлөгөөгөөр 65250.9 сая төгрөг, гүйцэтгэлээр 60668.5 сая төгрөгийг зарцуулж, 4452.5 сая төгрөгөөр буюу 95.3 хувьтай байна.

2019 оны төсвийн нийт зарлагын 95.0 хувь буюу 57652.4 сая төгрөгийг урсгал зардал, 2.9 хувь буюу 1753.7 сая төгрөгийг хөрөнгийн зардал, 2.1 хувь буюу 1262.4 сая төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээлийн үлдэгдэл эзэлж байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар батлагдсан зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 62122.9 сая төгрөг буюу 3128.9 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих санхүүжилт 309.5 сая дутуу санхүүжигдсэнтэй холбоотой байна. Төсвийн зарлагын гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар харуулбал:

Хүснэгт №5 Аудитлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мян.төг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		хэтрэлт, хэмнэлт
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,250,998.90	60,668,543.84	(4,582,455.06)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,599,481.60	57,652,440.91	(2,947,040.69)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,529,701.70	53,226,148.29	(2,303,553.41)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,264,246.10	28,943,861.03	(320,385.07)
210101	Үндсэн цалин	21,135,358.80	21,026,713.09	(108,645.71)
210102	Нэмэгдэл	4,594,785.00	4,521,542.65	(73,242.35)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	113,022.40	106,006.77	(7,015.63)
210104	Урамшуулал	2,754,672.40	2,634,590.42	(120,081.98)
210105	Гэрээт ажлын хөлс	666,407.50	655,008.10	(11,399.40)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,663,521.70	3,621,556.77	(41,964.93)
210201	Тэтгэврийн даатгал	2,492,396.90	2,473,466.07	(18,930.83)
210202	Тэтгэмжийн даатгал	292,791.60	291,762.99	(1,028.61)
210203	ҮОМШӨ-ний даатгал	234,233.30	227,369.23	(6,864.07)
210204	Ажилгүйдлийн даатгал	58,544.30	60,316.92	1,772.62
210205	Эрүүл мэндийн даатгал	585,555.60	568,641.56	(16,914.04)
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,345,992.40	6,188,326.53	(157,665.87)
210301	Гэрэл, цахилгаан	525,686.10	487,239.51	(38,446.59)
210302	Түлш, халаалт	5,533,689.30	5,454,764.20	(78,925.10)
210303	Цэвэр, бохир ус	286,617.00	246,322.82	(40,294.19)

2104	Хангамж, бараа материалын зардал	1,726,887.10	1,613,614.63	(113,272.47)
210401	Бичиг хэрэг	122,716.60	121,768.24	(948.36)
210402	Тээвэр, шатахуун	719,418.30	669,824.62	(49,593.68)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	108,908.20	106,104.04	(2,804.16)
210404	Ном, хэвлэл	65,696.80	15,645.78	(50,051.02)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	47,576.40	43,142.52	(4,433.89)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	662,570.80	657,129.43	(5,441.37)
2105	Норматив зардал	2,470,642.90	2,353,502.55	(117,140.35)
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	338,245.60	321,877.74	(16,367.86)
210502	Хоол, хүнс	1,934,147.80	1,860,245.03	(73,902.77)
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	198,249.50	171,379.78	(26,869.72)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	799,283.70	772,460.00	(26,823.70)
210601	Багаж, техник, хэрэгсэл	324,708.40	307,227.84	(17,480.56)
210602	Тавилга	86,901.40	79,617.65	(7,283.75)
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,779.60	3,542.53	(237.07)
210604	Урсгал засвар	383,894.30	382,071.98	(1,822.32)
2107	Томилолт, зочны зардал	424,562.90	392,570.75	(31,992.15)
210701	Гадаад албан томилолт	87,100.00	81,537.20	(5,562.80)
210702	Дотоод албан томилолт	337,462.90	311,033.55	(26,429.35)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,610,061.80	1,537,790.12	(72,271.68)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,564,261.50	1,497,058.55	(67,202.95)
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,736.70	10,192.48	(1,544.22)
210803	Даатгалын үйлчилгээ	13,738.70	12,780.53	(958.17)
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,830.30	6,759.30	(1,071.00)
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,605.80	3,068.17	(537.63)
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,200.00	4,163.50	(36.50)
210807	Газрын төлбөр	3,769.90	3,387.32	(382.58)
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	840.10	301.47	(538.63)
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	78.80	78.80	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,224,503.10	7,802,465.92	(1,422,037.18)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,668,089.50	7,254,705.32	(1,413,384.18)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	556,413.60	547,760.60	(8,653.00)
212	ТАТААС	43,801.60	36,801.60	(7,000.00)
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	12,000.00	5,000.00	(7,000.00)
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	12,000.00	5,000.00	(7,000.00)
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	31,801.60	31,801.60	-
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	31,801.60	31,801.60	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,025,978.30	4,389,491.02	(636,487.28)
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,808,359.70	3,250,473.62	(557,886.08)
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	3,808,359.70	3,250,473.62	(557,886.08)
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,217,618.60	1,139,017.40	(78,601.20)
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	159,995.00	131,147.00	(28,848.00)
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	137,674.00	137,148.14	(525.86)
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	525,581.00	508,512.54	(17,068.46)
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	241,047.40	219,671.71	(21,375.70)

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	153,321.20	142,538.01	(10,783.19)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,856,245.30	1,753,688.98	(102,556.32)
2200	Дотоод эх үүсвэрээр	1,856,245.30	1,753,688.98	(102,556.32)
220001	Барилга байгууламж	9,800.00	4,353.25	(5,446.75)
222001	Тоног төхөөрөмж	10,000.00	10,000.00	-
223001	Бусад хөрөнгө	1,836,445.30	1,739,335.73	(97,109.57)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,795,272.00	1,262,413.95	(1,532,858.05)
230001	Эргэж төлөгдөх зээл	2,795,272.00	1,262,413.95	(1,532,858.05)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,250,998.90	62,122,934.54	(3,128,064.36)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	31,081,217.00	30,736,141.67	(345,075.33)
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,310,383.50	1,310,383.50	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	29,770,833.50	29,425,758.17	(345,075.33)
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,462,700.00	29,059,862.57	2,597,162.57
132001	Орон нутгийн төсвөөс	22,892,628.90	25,544,449.44	2,651,820.54
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	3,570,071.10	3,515,413.14	(54,657.96)
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	420,497.50	100,661.08	(319,836.42)
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	420,497.50	100,661.08	(319,836.42)
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,286,584.40	2,226,269.22	(5,060,315.18)
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,951,537.40	2,110,912.40	(840,625.00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	110,940.00	115,356.82	4,416.82
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	4,224,107.00	-	(4,224,107.00)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,827,221.32	1,827,221.32
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,969,628.52	1,969,628.52
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	124	124	-
610001	Төсвийн байгууллага	124	124	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2,820	2,812	(8)
620001	Удирдах ажилтан	236	236	-
620002	Гүйцэтгэх ажилтан	1,748	1,745	(3)
620003	Үйлчлэх ажилтан	607	610	3
620004	Гэрээт ажилтан	229	221	(8)
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	14,366	14,283	(83)
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	10,006	10,253	247
630001	Төрийн өмчит ЕБС	10,006	10,253	247
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	4,360	4,030	(330)
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	4,360	4,030	(330)
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	2,820	2,812	(8)
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	290	287	(3)
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	1,019	1,027	8
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	129	129	-
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	234	234	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1,010	997	(13)
650010	Гэрээт ажилтан	11	11	-
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	127	127	-

Эх сурвалж: ТЕЗ-ийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Батлагдсан төсвөөс эдийн засгийн ангиллаар материаллаг дүнтэй зардлын гүйцэтгэлийг харьцуулан судалж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 362.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлтэй холбоотой төрийн жинхэнэ албан хаагчийн орон тоо нөхөгдөөгүйтэй холбоотой 8 орон тоотойгоор дутуу ажилласнаас,
2. Байр ашиглалттай холбоотой зардал 78.9 сая, цэвэр усны зардал 40.3 сая дутуу зарцуулсан нь түлш халаалт, усан бассейны цэвэр усны зардал дулааны цахилгаан станц ашиглалтад орох үед дулааны доголдол гарсантай холбоотой “Булган Мээж” ОНӨК халаалт ашиглаагүй өдрийг хасаж тооцсоноос,
3. Норматив зардлыг 117.1 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь оны эхэнд материалын үлдэгдэлтэй байсан, дотуур байрны хүүхдүүд хагас, бүтэн сайн өдрүүдэд гэртээ харьдгаас хүүхэд өдрийн гүйцэтгэлээр зардлыг олгосон, малын гоц халдварт шүлхий өвчин гарч ЕБС, СӨБ-ийн байгууллагын үйл ажиллагааг түр хугацаанд зогсоосонтой холбоотойгоор,
4. Томилолтын зардлыг 26.4 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь төсөв захирагч нар ажлын гүйцэтгэлийг үндэслэн албан томилолтыг олгодог болсонтой холбоотойгоор,
5. Ном хэвлэлийн зардлыг 50.1 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хөгжлийн хөтөч” ном хэвлүүлээгүйгээс,
6. Төрийн албан хаагчдаас тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 21.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь Могод сумын ЗДТГ-ын дарга тэтгэврээ тогтоолгоогүй ажиллаж байгаагаас,
7. Хөрөнгийн зардлыг 102.6 сая төгрөгөөр дутуу зарцуулсан нь замын сангийн хөрөнгөөр хийгдэх залуус хорооллын зураг төсвийн үнэ Сангийн яамны гүйлгээ хаагдсанаас хойш төсвийн жил дуусахад үед гэрээ хийгдсэн холбоотой шилжүүлээгүй үлдсэнээс тус тус хэмнэгдсэн байна.

Мөн Төсвийн гүйцэтгэлийн тайланд 14 сумдын санхүү албаны дарга нарын Хятад улсын Хайнан арлын аялал, сургалтын 32.6 сая төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын дансанд буруу төлөвлөн зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Гадаад албан томилолтын зардлыг хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал дансанд төлөвлөн зарцуулсан байна. /Хутаг-Өндөр, Гурванбулаг, Хангал сумын ЗДТГ-аас бусад бүх сумдууд/
- Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон. /Булган сумын 3-р сургууль, Бугат, Булган, Орхон, Сайхан сумын ЗДТГ, Булган сумын ТҮА, Хутаг-Өндөр, Баян-агт сумын цэцэрлэг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар/
- Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч нарт аймаг, сумын Засаг даргын захирамжаар үр дүнгийн урамшуулал давхардуулан олгосон /Булган сумын 1, 2, спортын дунд сургууль, Гурванбулаг, Могод,

Орхон, Рашаант, Тэшиг, Хангал, Бугат, Баяннуур сумын ЕБС, Баян-Агт, Бугат, Баяннуур, Бүрэгхангай, Орхон, Рашаант, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Хялганат, Булган сумын 1, 2, 3, 4, 6, 7-р цэцэрлэг/

- Төсөвт батлагдаагүй удаан жилийн нэмэгдэл олгосон, ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш тэтгэмж олгосон. /Цоожид өрхийн ЭМТ/
- Төсөвт батлагдаагүй удаан жилийн нэмэгдлийг олгосон, 3 албан тушаал зэрэг хавсарсан нэмэгдэл олгосон /Эмийн цэцэглэн өрхийн ЭМТ/
- Шагналын дагалдах мөнгөн урамшуулал олгосон. /Цоожид ӨЭМТ, Аймгийн ЗДТГ, Могод сумын ЗДТГ/
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн. /Эмийн цэцэглэн ӨЭМТ, Илчит Хутаг ОНӨААТҮГ, Гурванбулаг, Могод, Тэшиг, Баяннуур сумын ЕБС, БТСГазар/
- Хувь хүний сугалаатай баримтаар худалдан авч бүртгэлд тусгасан. /Тэшиг-Ус ОНӨААТҮГ, Булган Мээж ОНӨК/
- Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан /Булган сумын ИТХ/
- Байгууллагын дотоод журмыг зөрчин албан хаагчдад тэтгэмж олгосон. /Аймгийн ЗДТГ/
- Цалингийн зардлаас ахмадын санд зориулалт бус зардал гаргасан / Булган сумын 1,3,6,7-р цэцэрлэг, Баяннуур Гурванбулаг сумын цэцэрлэгүүд, Орхон сумын ЕБС, Рашаант сумын ЗДТГ/
- Малын гоц халдварт шүлхий өвчний үед ажилласан төрийн албан хаагчид цалингийн зардлаас урамшуулал олгосон / Рашаант, Гурванбулаг сумын цэцэрлэг Рашаант сумын ЗДТГ, ИТХ, Соёлын төв/
- Дотуур байрны хүүхдэд олгох нэг өдрийн хоолны норматив зардлыг хэтрүүлсэн. /Тэшиг, Хишиг-Өндөр, Баян-Агт, Бүрэгхангай, Дашинчилэн, Гурванбулаг, Могод, Булган сумын 1-р ЕБС/
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу шатахуун зарцуулсан / Гурванбулаг, Хишиг-Өндөр, Эрдмийн өргөө цогцолбор сургууль/
- ЕБС, СӨБ-ууд хүнсний материал нийлүүлэх тендер сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй. /Орхон сумын ЕБС, Гурванбулаг, Орхон, Тэшиг, Хялганат тосгон, Булган сумын 1,2,3,4,6,7-р цэцэрлэгүүд/
- Хөрөнгө бэлтгэх зөвшөөрөлгүйгээр бусдаар гүйцэтгүүлэх зардлаас тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдаж авсан. /ГБХЗХГ, Булган сумын ЗДТГ/
- Тогтмол зардлаас хөрөнгө бэлтгэсэн. /Булган сумын 1-р цэцэрлэг/
- Хог тээврийн машин худалдан авахдаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, шууд гэрээгээр худалдан авсан. /Булган сумын ЗДТГ/
- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс тоног төхөөрөмж техник хэрэгсэл, авто машин худалдан авсан. /Булган сумын ЭӨЦСургууль, Прокурорын газар, Хутаг-Өндөр сумын "Гуртын гүүр"-ийн мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын хэсгийн алба, Цагдаагийн газар/

Хүснэгт №6 Төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сумдаар: /сая.төг/

Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
БАЯН-АГТ	2,324.9	2,198.0	94.5	ТЭШИГ	2,819.9	2,691.0	95.4
БУГАТ	1,702.7	1,589.0	93.3	ХАНГАЛ	1,517.1	1,395.3	92.0
БҮРЭГХАНГАЙ	2,952.4	2,407.7	81.6	ХИШИГ-ӨНДӨР	2333.6	2,217.9	95.0
ГУРВАНБУЛАГ	2,470.3	2,200.0	89.1	ХУТАГ-ӨНДӨР	3256.2	3,054.3	93.8
ДАШИНЧИЛЭН	2,547.4	2,320.3	91.1	БУЛГАН	10403.3	9,950.1	95.6
МОГОД	2,056.0	1,846.4	89.8	БАЯННУУР	1838	1,759.5	95.7
ОРХОН	1,867.1	1,685.0	90.2	РАШААНТ	2862.7	2,687.5	93.9
САЙХАН	2,444.3	2,213.1	90.5	ХЯЛГАНАТ	2595.4	2,566.2	98.9
СЭЛЭНГЭ	2,808.9	2,731.1	97.2	ТӨВ ШУУД	16433.3	15,156.0	92.2

Эх сурвалж: СТСХ-ийн мэдээлэлд үндэслэв.

Төсвийн зарлагын гүйцэтгэл захирагчаар:

ТЕЗ-ийн 2019 оны төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтыг төсвийн захирагчаар авч үзэхэд 44.0 хувь буюу 26713.3 сая төгрөгийг аймгийн Засаг даргын багц, 45.9 хувь буюу 27831.4 сая төгрөгийг БСШУСС-ын багц, 0.8 хувь буюу 456.3 сая төгрөгийг БХБС-ын багц, 8.9 хувь буюу 5376.8 сая төгрөгийг ЭМС-ын багц, 0.5 хувь буюу 290.8 сая төгрөгийг ХНХС-ын багц тус тус эзэлж байна.

Төсвийн гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад аймгийн Засаг даргын багц 92.0 сая, БСШУСС-ын багц 2256.2 сая, ЭМС-ын багц 1019.9 сая, БХБС-ын багц 83.4 сая, ХНХС-ын багц 71.8 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт №7 Төсвийн зарлагын харьцуулалт

/сая төг/

Төсвийн захирагч	Өмнөх оны гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Харьцуулалт		
				Эзлэх хувь	Хэтрэлт + Хэмнэлт -	Өмнөх оны гүйцэтгэлээс
Аймгийн Засаг дарга	26,621.3	30,550.1	26,713.3	44.0	(3,836.8)	92.0
БСШУСС	25,575.2	28,172.8	27,831.4	45.9	(341.4)	2,256.2
ЭМС	4,356.9	5,761.5	5,376.8	8.9	(384.7)	1,019.9
БХБС	372.9	475.8	456.3	0.8	(19.5)	83.4
ХНХС	218.9	290.7	290.7	0.5	-	71.8
Дүн	57,145.2	65,250.9	60,668.5	100.0	(4,582.4)	3,523.3

Эх сурвалж: СТСХ-ийн мэдээлэлд үндэслэв.

Засаг даргын ерөнхий дансны гүйцэтгэл:

Аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор 5 хөтөлбөр арга хэмжээнд батлагдсан 5825.5 сая төгрөгийг аймгийн Засаг даргын ерөнхий дансаар 100 хувийн гүйцэтгэлтэй зарцуулсан байна. Үүнд:

- Гүйцэтгэлээр ойн цөлжилтийн 12 арга хэмжээнд 754.8 сая, усны нөөцийг хамгаалах, усан хангамжийг сайжруулах 27 арга хэмжээнд 2853.3 сая, газар газрын хэвлийг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлыг багасгах 18 арга хэмжээнд 1765.9 сая, биологийн төрөл зүйлийг хамгаалах 4 арга хэмжээнд 32.7 сая төгрөг,
- Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан 8 хөтөлбөр арга хэмжээнд 350.0 сая төгрөг,
- Техник хяналтын зардал 25.0 сая, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, ЕБС-ийн хүүхдэд зориулсан нийтийн тээврийн үйлчилгээнд 12.0 сая төгрөг зарцуулагдсан байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэл хөтөлбөрөөр:

Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнг ханган ажилласан байна. ТЕЗ 2019 онд 3 арга хэмжээ 21 хөтөлбөрийг хэрэгжүүлж нийтдээ 60668.5 сая төгрөгийг зарцуулж ажилласан байна. ТЕЗ, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлтийн нутгийн өөрөө удирдах ёсны үйл ажиллагааны хөтөлбөр 96.7 хувь, орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагын хөтөлбөр 92.9 хувьтай хэрэгжсэн байна.

2019 оны төсвийн зарцуулалтыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал нийт дүнгээр 3519.0 сая төгрөг буюу 5.8 хувиар, урсгал зардал 6817.7 сая төгрөг буюу

11.8 хувиар, хөрөнгийн зардал 465.6 сая төгрөгөөр буюу 8.7 хувиар нэмэгдэж, эргэж төлөгдөх цэвэр зээл 245.9 сая төгрөгөөр буюу 19.5 хувиар буурсан байна.

Урсгал зардал өмнөх оноос 6817.7 сая төгрөг буюу 11.8 хувиар өссөн нь МУ-ын Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдаж төрийн албан хаагчдын улирлаар олгох үр дүнгийн урамшуулал нэмэгдсэн, ЗГ-ын 24 дүгээр тогтоолоор төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоож төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн, мөн байгууллагаас төлөх НДШ-ийн хувь хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Эргэж төлөгдөх цэвэр зээл 245.9 сая төгрөгөөр буюу 19.5 хувиар буурсан нь Сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор зээл олголт буурсантай холбоотой байна.

БҮЛЭГ 3. АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2019 ОНД ХҮРЭХ ҮР ДҮНГ ТОДОРХОЙЛОН БАТАЛСАН БОЛОВЧ ДОТООД АУДИТ ХИЙГЭЭГҮЙ БАЙНА.

3.1 Аймгийн ТЕЗ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тоо болон чанарын үзүүлэлтийн хүрэх үр дүнг тодорхойлон баталсан боловч дүгнэж, нэгтгэж, дүн шинжилгээ хийж ажиллаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.5³-д заасны дагуу Булган аймгийн ИТХ-ын Хуралдааны 2019 оны ээлжит XIII хуралдааны 13/01 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар аймгийн ТЕЗ-д хамаарах Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, гүйцэтгэх засаглалын удирдлага, Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнг баталсан байна.

Харин сумын ИТХ-аар төсвийн эрх захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн чанар болон тоон үзүүлэлт үзүүлэлтийг хөтөлбөр арга хэмжээгээр нь задлаагүй, нэг хөтөлбөрөөр хэдэн арга хэмжээ хэрэгжүүлэх ямар тоон үзүүлэлтэд хүрэх нь тодорхойгүй, төсөвт өөрчлөлт хийхдээ хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүнгийн тоон үзүүлэлтийг нэмж тодотгож өөрчлөлт оруулаагүй байна.

Аймгийн Засаг дарга яамдуудтай хамтран ажиллах гэрээг оны дараа 1,2-р сард байгуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2⁴ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Мөн аймгийн ИТХ-ын хуралдаанаар аймгийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн хүрэх үр дүнг баталсны дараа аймгийн ТЕЗ яамдуудтай гэрээ байгуулж байгаагаас хөтөлбөрийн үр дүн аймгийн ИТХ-аар батлагдсантай уялдахгүй байна.

3.2 Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтэд дотоод хяналтыг хэрэгжүүлэхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1⁵-д зааснаар аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээний биелэлтэд хуулийн 39.5⁶-д заасны дагуу аудит хийгээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын хяналт, шинжилгээ, аудитын хэлтсээс байгууллагуудад хяналт хийхдээ аймгийн ИТХ-аар баталсан хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн хэрэгжилтэд хяналт тавьдаггүй, биелэлтийг тооцдоггүй байна.

³ төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах;

⁴ Энэ хуулийн 14.1.6, 14.1.8-д заасан төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг даргатай энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 14 өдрийн дотор байгуулна.

⁵ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

БҮЛЭГ 4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 94.4 ХУВЬТАЙ БАЙНА.

4.1 Хөрөнгө оруулалтын төсвийн гүйцэтгэл өмнөх оноос 9.6 хувиар өссөн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд улсын төсвөөс ОНХС-д 3570.1 сая, Орон нутгийн төсвөөс замын сангийн арга хэмжээнд 342.0 сая, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1447.2 сая, аймгийн Засаг даргын тамгын газар 67.0 сая нийт 5426.3 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 5269.1 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Замын сангийн хөрөнгө оруулалтаар 5 арга хэмжээнд 342 сая төгрөгийг батлагдсанаас гүйцэтгэлээр 245.1 сая төгрөгийг санхүүжүүлэн, 96.9 сая төгрөгийн Булган сумын Залуус хорооллын авто зам барих зураг төслийг санхүүжилтийг гэрээ байгуулагдаагүйн улмаас зарцуулаагүй байна.

2019 онд Улсын төсвөөс ОНХС-д 3570.1 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 3515.4 сая төгрөгийг санхүүжүүлэн 180 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн 98.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад 28 төсөл арга хэмжээнд 1402.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1402.2 сая төгрөгийн санхүүжилт олгож 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Харин Байгаль хамгаалах санд 73 төсөл арга хэмжээнд 5406.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 4573.9 сая төгрөгийг санхүүжүүлэн 85 хувийн гүйцэтгэлтэй байна.

БҮЛЭГ 5. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ӨМНӨХ ОНООС 1903.9 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДСЭН БАЙНА.

5.1 Нэмэлт төсвийн гүйцэтгэлээр 5240.5 сая төгрөгийг зарцуулан 179.8 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

Тайлант онд хандив тусламжаар 92.8 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөр 3937.7 сая, дээд шатны төсвийн захирагчаас 1234.9 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 154.9 сая нийт 5420.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

⁶ Энэ хуулийн 39.1, 39.2-т заасан гэрээний биелэлтийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч хагас, бүтэн жилээр дүгнэж, дотоод аудит хийнэ.

Үүнээс цалин, НДШ-ийн зардалд 36.8 сая, тогтмол зардал 9.1 сая, бараа материалын зардалд 365.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 911.3 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 3270.7 сая, тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 127.8 сая төгрөг, хөрөнгийн зардалд 519.2 сая нийт 5240.5 сая төгрөгийг зарцуулсан байна.



Эх сурвалж: ТЭЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаас

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Аймгийн ТЭЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.6-д заасан бүрэлдэхүүн тус бүрээр гаргаж, төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж ажиллаагүй байна.
2. Орон нутгийн төсвийн орлого үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого тасарснаас шалтгаалж 287.4 сая төгрөгөөр тасалсан байна.
3. Гадаад албан томилолтын зардалд олгосон 32.9 сая төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд хичээл үйлдвэрлэлийн зардалд төлөвлөн, тайлагнасан байна.
4. Аймгийн ТЭЗ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тоон болон чанарын үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

1. Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн тус бүрээр төсвийн гүйцэтгэлийн 2020 оны эхний хагас жилийн тайланг гаргаж Төрийн аудитын байгууллагад ирүүлэх,
2. Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж ажиллах, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах.

3. Аймгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг бодитой төлөвлөж, үндэслэлийг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллах.
4. Гадаад албан томилолтын зардлыг төлөвлөж зарцуулахдаа зардлын эдийн засгийн ангиллыг зөв тайлагнаж байх.
5. Аймаг, сумын төсөвт төвлөрч байгаа татварын болон газрын төлбөрийн орлогыг аккруэл сууриар бүртгэх.
6. Газрын төлбөрийн орлогыг ногдуулалтаар тооцож Төрийн аудитын байгууллагад ирүүлэх, өмнөх оны орлогын дутууд дүн шинжилгээ хийж ажиллах.
7. Аймгийн ТЕЗ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тоон болон чанарын үзүүлэлтийн биелэлтэд дотоод аудит хийж, үр дүнг тооцож ажиллах.

Зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн ажил, түүний хэрэгжилт, үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР